



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Н.ГАНБЯМБА ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn


2018.07.06 № 05/5817  
танай 2018.06.27-ны № 9/1150 -т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Цэцэрлэгийн эрхлэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Цэрэнхандын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч С.Цэрэнханд нь тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан дээд боловсролын зэрэгтэй байх гэсэн шаардлагыг хангаагүй, мөн Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу сонгон шалгаруулалтад оролцоогүй байх тул нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн нэр дэвшүүлж томилоход анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

  
*Хашбаатар*  
Х.ХАШБААТАР